



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 44,600,000 (дөчин дөрвөн сая зургаан зуун мянга) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаартай албан даалгаврын биелэлтээр 91.4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Ю.Ганзориг)-д үүрэг болгосугай.

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй, хэмнэлттэй, үр ашигтай ажиллах;

2.3. Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд бий болсон, 198.6 (нэг зуун ерэн найман сая зургаан зуу) сая төгрөгийн насжилт ихтэй, өндөр дүнтэй урт хугацаат өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах;

2.4. Зам, засвар арчлалтын ажилд зарцуулах бараа материалыг Нягтлан бодох болон бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, норм стандарт, журмын дагуу захиран зарцуулж, хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллах.

2.5. “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг тусгай зориулалт бүхий тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

2.6. Архангай аймгийн Тариат сумын төвд байрлах, 1983 онд ашиглалтад орсон, 256.12 м.кв талбай бүхий 4 айлын орон сууц, 2007 онд ашиглалтад орсон 146.57 м2.кв талбай бүхий 3 автомашины гарааш, 1306 м2 талбай бүхий газар эзэмших эрх зэрэг нийт 34,742,900 (гучин дөрвөн сая долоон зуун дөчин хоёр мянга

есөн зуун) төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг данснаас хасах талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

3.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-эрдэнэ)-т нарт тус тус даалгасугай.

4.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 2 дугаар, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны ...~~29~~ дугаар сарын ...~~29~~ ны өдрийн
~~29~~ дугаар тогтоолын хавсралт



“Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсэн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авч, бараа материалын дансанд бүртгэсэн	6.2	ТБОНӨТХ-ийн 11.8 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 618 дугаар тогтоол	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө олж авах
2	МУЗГ-аас хариуцан дулааны төлбөрийг төлсөн атал орон сууцанд амьдардаг ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1.4	Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”	Төсвийг үр ашигтай зарцуулах
3	Тайлант хугацаанд хөндлөнгийн гишүүнээр үнэлгээний хорооны даргын үүргийг хариуцуулдаг	-	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47, журмын 8.1, 8.4 дэх заалт	Холбогдох хууль, журамд нийцүүлж үнэлгээний хорооны даргыг томилох
4	Худалдан борлуулсан 2 ширхэг тээврийн хэрэгслийг тайлант хугацаанд нь данснаас хасаагүй	43.2	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”	Үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг гарсан тухай бүр данс бүртгэлд тусгаж байх
Нийт дүн		44.6	(дөчин зургаан сая зургаан зуун мянга)	